

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 10 сар 05 өдөр

Дугаар А-262/262

Засхиргваны хэмжээний  
актн улсын нэгдсэн сан  
2021 оны 10 сарын 21  
бонцогийн түүрээний  
Улаанбаатар хот

Журам батлах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.11 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 347 дугаар тогтоол, Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын 12 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Наандалай), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд тус тус даалгасугай.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА





Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах  
хорооны даргин 2021 оны 10 дугаар сарын ... -ны  
одрийн 17/2021 тоот хамтарсан тушаалын хавсралт

## ХУВЬЦААТ КОМПАНИ ХЭЛБЭРТЭЙ БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахад Монголбанкаас зөвшөөрөл авах, Монголбанкинд мэдэгдэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах байдлаар өөрчлөлт орох тухай бүр Монголбанкаас зөвшөөрөл авна:

1.2.1. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах;

1.2.2. Банкийг нийлүүлэх, иэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;

1.2.3. Банкны нэгж хувьцааны нэрлэсэн үнийг осгөх, эсхүл бууруулах;

1.2.4. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох;

1.2.5. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч банкны нийт гаргасан хувьцааны I (нэг) болон түүнээс дээш хувиар хувьцаа нэмж эзэмших;

1.2.6. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасаа эргүүлэн худалдан авах.

1.3.Банк нь банкны хувьцаа эзэмшигчдийн бүтцэд энэ журмын 1.2-т зааснаас бусад байдлаар өөрчлөлт ороход энэ журмын 5 дугаар зүйлд заасны дагуу Монголбанкинд мэдэгдэнэ.

1.4.Монголбанкаас энэ журамд заасны дагуу зөвшөөрөл олгосон тохиолдолд банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг нийтэд санал болгон эсхүл хаалттай хүрээнд гаргахаар бүртгүүлэх, банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг худалдах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын холбогдох журмаар зохицуулна.

1.5.Банкны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 69 дүгээр зүйлийн 69.1.14-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж буй банканд энэ журам хамаарахгүй.

### ХОЁР. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

2.1.Банк энэ журмын 1.2.1-д заасан зөвшөөрлийг авахдаа зөвшөөрөл хүссэн албан бичгийг дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ:

2.1.1. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргахтай холбоотой банкны эрх бүхий этгээд (хувьцаа эзэмшигчид эсхүл төлөөлон удирдах зөвлөл)-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр; *Г.Р. Г.Г.*

2.1.2. Гаргах хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны тоо, хэмжээ, үнэт хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөгөө; *Г.Р. Г.Г.*

2.1.3. Боломжит хөрөнгө оруулагчдын талаарх тандан судалгаа.



2.2. Банк энэ журмын 1.2.2-т заасан зөвшөөрлийг авахдаа зөвшөөрөл хүссэн албан бичгийг Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасан баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ.

2.3. Банк энэ журмын 1.2.3-т заасан зөвшөөрлийг авахдаа зөвшөөрөл хүссэн албан бичгийг банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэлийн хамт Монголбанкинд ирүүлнэ.

2.4. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд энэ журмын 1.2.4-т заасан зөвшөөрлийг авахдаа Банкны тухай хуулийн 36.19-д заасан шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг болон дараах тодорхойлолт, баримт бичгийг банкаар дамжуулж Монголбанкинд ирүүлнэ:

2.4.1. Энэ журмын Хавсралт 2-т заасан мэдээлэл бүхий банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн тодорхойлолт;

2.4.2. Энэ журмын Хавсралт 3-т заасан мэдээлэл бүхий банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн мэдүүлэг;

2.4.3. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

2.4.4. Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт, павлагаа;

2.4.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгө нь хууль ёсны үйл ажиллагааны орлого болохыг нотлох баримт;

2.4.5.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд хувь хүн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогын тодорхойлолт, татварын албаны тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга;

2.4.5.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол харьалах татварын байгууллагаас баталгаажуулсан сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд хувь хүн бол бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Хувь хүний орлогын албан татварын тайлан”, татварын албаны тодорхойлолт;

2.4.6. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхэд Монголбанкаас хуулийн дагуу шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;

2.4.7. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог тогтооход Монголбанкаас хуулийн дагуу шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;

2.4.8. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь гадаадын харьалалтай хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй холбоотой дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ:

2.4.8.1. Харьалах улсад зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолт;

2.4.8.2. Харьалах улсад эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт;

2.4.9. Гадаадын харьалалтай хувь хүн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох тохиолдоид

2.4.8.1, 2.4.8.2-т заасан баримт бичгийг нэмж ирүүлнэ.

2.5. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч энэ журмын 1.2.5-д заасан зөвшөөрлийг авахдаа энэ журмын 2.4.5-д заасан баримт бичгийг банкаар дамжуулж Монголбанкинд ирүүлнэ.



2.6. Банк энэ журмын 1.2.6-д заасан зөвшөөрлийг авахдаа зовшөөрөл хүссэн албан бичгийг дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ:

2.6.1. Хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг эргүүлэн худалдан авах тухай банкны эрх бүхий этгээд (хувьцаа эзэмшигчид, эсхүл төлөөлөн удирдах зөвлөл)-ийн хурлын шийдвэр (буцаан худалдан авах хувьцааны тоо, нэг бүрийн үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам, буцаан худалдан авах болсон шалтгаан, халаасны хувьцааг буцааж худалдах хугацаа, журам зэргийг тодорхой тусгасан байна), хурлын тэмдэглэл;

2.6.2. Хувьцааг эргүүлэн худалдан авч халаасны хувьцаанд бүртгэсний дараа Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангаж байгааг харуулсан тооцоо, судалгаа, дүгнэлт;

2.6.3. Компанийн тухай хуулийн 49.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр хувьцааг эргүүлэн худалдаж авах бол хувьцаа эзэмшигчтэй хийсэн хэлцэл;

2.6.4. Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн дагуу хувьцаа эзэмшигчийн шаардлагаар банк хувьцаагаа эргүүлэн худалдан авах тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан шаардлага, түүний шалтгаан.

2.7. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах харилцаанд гадаадын харьяалтай хуулийн этгээд, хувь хүн оролцсон бол энэ журамд холбогдох баримт бичгийг тухайн улсын хэлээр үйлдэж, монгол болон англи хэл дээрх албан орчуулгын хамт Монголбанкинд ирүүлнэ.

2.8. Монголбанк энэ журамд заасан баримт бичгээс гадна хуулийн дагуу шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээ, баримт материал шаардах эрхтэй бөгөөд банкны хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагаас мэдээлэл, тодорхойлолт, лавлагaa гаргуулан авна.

## **ГУРАВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

3.1. Монголбанк нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлтийг хянаж, хуулийн дагуу шаардлагатай тохиолдолд тайлбар, тодруулга авч, газар дээр нь шалгана.

3.2. Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд Монголбанк нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг шаардах бөгөөд бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

3.3. Монголбанк энэ журмын 1.2-т заасан зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ энэ журмын 3 дугаар зүйлд заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагч банк, Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 3 (гурав) хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.4. Монголбанк шаардлагатай гэж үзвэл энэ журмын 3.3-т заасан шийдвэр гаргах хугацааг 30 (гуч) хүртэл хоногоор сунгаж болно.

## **ДОРӨВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ**

4.1. Монголбанк нь дараах үндэслэлээр банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохоос татгалзана:

4.1.1. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь Банкны тухай хуульд заасан шалгуурыг хангаагүй;



- 4.1.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулах өөрчлөлт нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн;
- 4.1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг энэхүү журмын шаардлагыг хангагүй, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого болох нь нотлогдоогүй;
- 4.1.4. Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийг нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;
- 4.1.5. Энэ журмын 3.2-т заасан баримт материалыг Монголбанк шаардсанаас хойш 30 (гуч) хоногийн дотор бүрэн гүйцэд ирүүлээгүй.

## ТАВ. МЭДЭГДЭХ, ТАЙЛАГНАХ

- 5.1.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд банкны нийт гаргасан хувьцааны 1 (нэг) хүртэл хувиар өөрчлөлт орох тохиолдолд банк энэ журмын 5.3, эсхүл 5.10-т заасны дагуу Монголбанкинд мэдэгдэнэ.
- 5.2.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 3 (гурав) хоногийн дотор хурал зарлагч этгээд нь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.3.Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор банк нь Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.4.Үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр зуучлуулан нээлттэй хувьцаат компани хэлбэртэй банкны хувьцаа эзэмшигч болох аливаа этгээд нь энэ журмын хавсралт 1-д заасан мэдээлэл бүхий банкны хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг тухайн үнэт цаасны брокерт үнэн зөв гаргаж өгнө.
- 5.5.Үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн зуучлалгүйгээр банкны хувьцаа эзэмшигч болох аливаа этгээд нь энэ журмын хавсралт 1-д заасан мэдээлэл бүхий банкны хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг тухайн банканд үнэн зөв гаргаж өгнө.
- 5.6.Үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь энэ журмын 5.4-т заасны дагуу харилцагчаас гаргаж өгсөн банкны хувьцаа эзэмшигч болох этгээдийн тодорхойлолтыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаад хүргүүлнэ.
- 5.7.Монголбанк нь банкны хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдийн мэдээллийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас авах эрхтэй.
- 5.8.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь энэ журмын хавсралт 2-т заасан банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүр банканд мэдэгдэж, тодорхойлолтоо ажлын 3 (гурав) хоногийн дотор шинэчлэн хүргүүлнэ.
- 5.9. Банк нь энэ журмын хавсралт 2-т заасан тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүр хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг шинэчилж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ.
- 5.10. Банк нь банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн тайланг дараах тохиолдолд дор дурдсан хугацаанд энэ журмын Хавсралт 4-ийн дагуу гаргаж, Монголбанкинд ирүүлнэ:
- 5.10.1. сар бүр дараа сарын 10-ны өдрийн дотор;
- 5.10.2. банкны нэг хувьцаа эзэмшигчийн хувь, хэмжээнд банкны нийт гаргасан хувьцааны 197 болон түүнээс дээш хувиар өөрчлөлт орох тухай бүр ажлын 3 (гурав) хоногийн дотор;
- 5.10.3. банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор ирүүлнэ.



5.11. Банк хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийн тайланг хагас жил тутам энэ журмын Хавсралт 5-ын дагуу гаргаж, Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан дараа сарын 10-ны одрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус ирүүлийн.

5.12. Монголбанк нь банкны хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчийн тухайлсан бүртгэл, түүний эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг тухайн хөрөнгө оруулалтын сантай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианаас авах эрхтэй.

### ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулсан этгээдэд Банкны тухай хуулийн 29.3, 36.7, 36.8-д заасан, мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авна.

6.2. Энэ журмыг зөрчсон этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



“Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд  
өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын Хавсралт 1

..... БАНКНЫ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А.БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

Оноосон нэр:	
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	
Байгуулагдсан огноо:	
Хуулийн этгээдийн улсын харьяалал:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Хаяг:	
Цахим хаяг:	
Холбоо барих утас:	

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Эзэмшиж буй хувьцааны хувь	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
...					
...					
...					



**Холбогдох этгээдүүд:**

	Овог, иэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
1					
2					
...					

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр



**Б. БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУВЬ ХҮН БОЛ:**

Ургийн овог:		Сүүлийн зургаан сарын дотор авхуулсан зураг
Овог:		
Нэр:		
Төрсөн огноо:		
Регистрийн дугаар:		
Иргэншил:		
Оршин суугаа хаяг:		
Цахим шуудангийн хаяг:		
Суурин болон гар утасны дугаар:		

**Холбогдох этгээдүүд:**

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
1					
2					
...					

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

..... оны ..... сарын .....-ний өдөр



“Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын Хавсралт 2

..... БАНКНЫ НӨЛӨӨ БУХИЙ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**А.НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:**

Оноосон нэр:	
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	
Байгуулагдсан огноо:	
Хуулийн этгээдийн улсын харьяалал:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Хаяг:	
Цахим хаяг:	
Холбоо барих утас:	

## Хувьсаа эзэмшигчийн мэдээлэл:

Овог, иэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Эзэмшиж буй хувьцааны хувь	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
...				
...				

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг диаграмм хэлбэрээр эцсийн өмчлөгч хүртэл тодорхойлж, доорх хүснэгтэд оруулна уу

(Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн охин болон хараат компани, хувьцаа эзэмшидэг компани, уусгэн байгуулагчийн толгой компани болон хувьцаа эзэмшигчид, төдгээрийн эзэмшилтийн хувийг харуулсан нарийвчилсан диаграммыг энд зурна уу)



**Холбогдох этгээдүүд:**

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
1					
2					
...					

**Эрх бүхий албан тушаалтан:**

1	Албан тушаал:	
	Овог, нэр:	
	Регистрийн дугаар:	
	Иргэншил:	
	Оршин суугаа хаяг:	
	Цахим шуудангийн хаяг:	
	Холбоо барих утас:	
...		

**Гүйцэтгэх удирдлагын түүх: (он дарааллаар бичнэ үү)**

	Албан тушаал	Овог нэр	Хугацаа
1			
2			
3			
...			

**Хараат болон охин компанийтай бол доорх хүснэгтийг бөглөнө үү:**

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1				
2				
3				
...				



**Өөр хуулийн этгээд, банканд хувь эзэмшдэг бол доорхыг баглөнө үү:**

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь
1		
2		
...		

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үзэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны ..... сарын .....-ний өдөр



**Б. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД НЬ ХУВЬ ХҮН БОЛ:**

Ургийн овог:		сүүлийн зургаан сарын дотор авхуулсан зураг
Овог:		
Нэр:		
Төрсөн огноо:		
Регистрийн дугаар:		
Иргэншил:		
Оршин суугаа хаяг:		
Цахим шуудангийн хаяг:		
Суурин болон гар утасны дугаар:		
Ажил эрхлэлт:		
Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:		
Ажлын хаяг, утасны дугаар:		
Урьд өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал: <i>(он дарааглаар бичнэ үү)</i>		

Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.

	Байгууллагын нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар 
1			

2			
...			

Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорхыг бөгленө үү.

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			

**Холбогдох этгээдүүд:**

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл	Улсын харьяалал
1					
2					
...					

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)




..... оны ..... сарын .....ний өдөр ХУУЛБАР ҮНЭН

“Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд  
өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын Хавсралт З

### ..... БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭДИЙН МЭДҮҮЛЭГ

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад банк, санхүүгийн байгууллага болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтаар томилогдох зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байсан уу? Таны хүсэлтийг хүлээж аваагүй, эсхүл татгалзсан тохиолдол бий юу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаarahгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
4	Та өөрийн өмнө ажиллаж байсан байгууллага, аж ахуйн нэгжийн хянан зохицуулагч байгууллага, мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
5	Та өмнө нь луйвар, залилан, эсхүл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдуулэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаarahгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.
6	Таны хувьцаа эзэмшдэг /гүйцэтгэх удирдлага, ажилтнаар нь ажилладаг/ үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байсан болон/эсхүл одоо байгаа байгууллага, нөхөрлөл нь торийн, мэргэжлийн, эсхүл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсхүл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.
8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.
10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхтэй холбоотой, эсхүл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсхүл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь ор толборроо бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсац уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.



Танын үсэг  
21 ОНДЫН 20 САРДАА

12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цүшлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
13	Та омнө нь итгэлцэл болон түүнтэй адилтгах харилцаанд зөрчил гаргаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү? Хэрэв үгүй бол шалтгаанаа дэлгэрэнгүй тайлбарлана уу.

Би энэ тодорхойлолтыг гаргаснаар мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан банкны байгууллагын хувьцаа эзэмшигч байх хугацаанд энэ асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэх болно.

Би дээрх мэдүүлгийн эсрэг баримт нотолгоо гарч ирсэн, эсхүл санаатай худал мэдүүлсэн тохиолдолд Банкны тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

Овог, нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_



“Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийгүүлсэн  
хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд  
өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын Хавсралт 4

### БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН

..... оны ..... сарын ....-ний өдрийн байдлаар

Хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдийн мэдээлэл									
Хувьцаа эзэмшигчийн хувь, хэмжээ	Хувьцааны хувь, хэмжээ хувиар/	Хувьцааны тоо	Хувьцааны тоо	Овог нэр /төг/	Регистрийн дугаар/	Харьяалах улс	Хувьцаа эзэмшигчтэй ямар холбоотой болох	Тухайн банкны хувьцаа эзэмшигч эсэх	Эзэмшиг буй хувьцааны хувь
1									
2									
3									



“Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэлд оорчлолт оруулах зөвшөөлийн журам”ын Хавсралт 5

## ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

..... оны ..... сарын ....-ний одрийн байдлаар

### I.Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өөрчлөлт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр Үлдэгдэл (он/сар/өдөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхийн Үлдэгдэл (+,-) (он/сар/өдөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд гарсан өөрчлөлт (+,-) (он/сар/өдөр)
1		
2		
..		



*2.Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмэс оруулсан хөрөнгийн гүйлгээний тэмдэглэлийн*

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний Улдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгө (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгө (төгрөгөөр)
1					
2					
...					

*3.Өрийг хувьцаанд ишигүүлсэн гүйлгээний тэмдэглэлийн*

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний Улдэгдэл	Хувьцаанд шилжүүлсэн өрийн мөнгөн дүн (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхийн Улдэгдэл
1					
2					



**4.Ногдол ашиг хувваарилсан гүйлээний тэмдээгийн төслийн**

Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний Үлдэгдэл	Хувваарилсан ногдол ашгийн Мөнгөн дүн (төгрөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн Эцсийн Үлдэгдэл
1				
2				
...				

**5.Хувьцааг эргүүлэн худалдан авсан гүйлгээний тэмдээгийн төслийн**

Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Эргүүлэн худалдан авсан хувьцааны мөнгөн дүн	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний Үлдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн Эцсийн Үлдэгдэл
1				
2				
...				



*6.Хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлийг шилжүүлсэн (худалдсан, шуухийн болон эрх хүлээн авагчийн шийдвэрээр хасалт хийсн болон нэмсн, гэрээслэлэр овлох, бэлгэлэлийн гэрээ болон бусад хууль ёсны замаар хувьцаа шилжүүлсэн) тухай тэмдэглэл*

Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Өмчлийг шилжүүлсэн хувьцааны мөнгөн дүн	Өмчлийг шилжүүлэх өгсөн хувьцаа эзэмшигчийн овог, нэр

